


ҮНДЭСНИЙ ТҮҮХ, СОЁЛ, УЛАМЖЛАЛ БОЛОН ХҮҮХЭД, ТАНИН МЭДЭХҮЙН НЭВТРҮҮЛГИЙГ 2025 ОНД ТЕЛЕВИЗ, РАДИОГООР НЭВТРҮҮЛСЭН ТАЙЛАН

Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасан чиг хүрээнд радио, телевизийн хөтөлбөрт тавигдах баталж, хэрэгжилтэд хяналт, мониторинг хийж байна. Тус хорооны 2021 оны 01 тоот тогтоолоор батлагдсан “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10, 3.12 дахь заалтуудын дагуу өргөн нэвтрүүлгийн телевизүүдэд, 2020 оны 87 тоот тогтоолоор баталсан “Радиогийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10 дахь заалтын дагуу радиогийн үйлчилгээ эрхлэгчдэд үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг, бэлтгэн нэвтрүүлэх үүргийг тус тус хүлээлгэдэг. ХХЗХ нь радио, телевизийн хөтөлбөрт хийдэг байнгын хяналт, мониторингийн тайланд үндэслэн улирал тутам дээрх үүргийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ дүгнэлт гарган ажиллаж байна.

Телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрийн мониторингийн 2025 оны дүнгээр Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизүүд үндэсний түүх, соёл, уламжлал, танин мэдэхүйн болон хүүхдийн нэвтрүүлгийг дараах байдлаар нэвтрүүлжээ.

1. УЛААНБААТАР ХОТЫН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТЕЛЕВИЗ


Монгол Улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевиз нь жилд 200 цагаас багагүй үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлэх үүрэгтэй бөгөөд 2025 онд өргөн нэвтрүүлгийн 18 телевизээр нийт 5493 цагийн нэвтрүүлэг нэвтрүүлсэн нь өнгөрсөн оноос 1748 цагаар өссөн үзүүлэлттэй байна. Телевиз тус бүрээр харахад Централ телевиз хамгийн их цагаар буюу 807 цагийн нэвтрүүлэг нэвтрүүлжээ. Мөн NTV, SBN, Монгол HD, Боловсрол суваг, Стар телевизүүд нь өнгөрсөн оноос тодорхой цагаар нэмэгдүүлсэн нь тус Хорооноос батлан гаргасан “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10.1 дэх заалтын хэрэгжилтийг бүрэн хангаж байна.



Үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлсэн нийт цаг		
Нийт ТВ тоо	2024 он /цаг/	2025 он /цаг/
18 телевиз	3745:04:50	5493:45:54

1.2 Монгол Улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевиз жилд 180 цагаас багагүй танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлэх үүрэгтэй бөгөөд 2025 онд Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18 телевиз нийт 6368 цагийн танин мэдэхүйн нэвтрүүлэг нэвтрүүлсэн нь өнгөрсөн оноос 1304 цагаар өссөн үзүүлэлттэй байна. Тодруулбал, NTV, Боловсрол суваг, Сүлд телевизүүд нь тус төрөл жанрын нэвтрүүлэгт түлхүү анхаарч шинэ бүтээл үйлдвэрлэлтээ нэмэгдүүлж өмнөх жилээс илүү олон цагаар нэвтрүүлжээ. Түүнчлэн Малчин, Монгол HD, ТВ8 телевизүүд танин мэдэхүйн төрлийн нэвтрүүлгийн цагийг нэмэгдүүлснээр “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10.4 дэх заалтын хэрэгжилтийг хангах хэмжээнд хүрч ажилласан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2.4 дэх заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.4 дэх заалт, Телевизийн хөтөлбөрт тавих шаардлагын 3.17-д зааснаар Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт хөтөлбөрөө хүргэж үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй телевизүүдэд мэдээ, мэдээллийн хөтөлбөр, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах үе шаттай төлөвлөгөөг өөрийн боломжид тулгуурлан төлөвлөж төлөвлөгөөний дагуу гаргах үүргийг хүлээлгэдэг ба тус хороо биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Танин мэдэхүйн нэвтрүүлгийг 2025 онд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт хөтөлбөрөө хүргэж үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 30 телевизээр 692:54:33 цагийн дохионы хэлний хэлмэрчтэй, 2168:14:16 цагийн хадмал тайлбартайгаар нэвтрүүлсэн байна. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад дохионы хэлний хэлмэрчтэй танин мэдэхүйн нэвтрүүлэг 33 цагаар буюу 3%-аар хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлэг нь 861 цагаар ба 3%-аар тус тус өсжээ.





Танин мэдэхүйн нэвтрүүлэг нэвтрүүлсэн нийт цаг		
Нийт ТВ тоо	2024 он /цаг/	2025 он /цаг/
18 телевиз	5063:29:06	6068:27:55

1.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевиз нь хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон, хөгжил, хүмүүжил, төлөвшилд нь чиглэсэн танин мэдэхүйн боловсрол олгох, балчир буюу 3+ насны ангилалтай нэвтрүүлэг жилд 90 цагаас багагүй, бага, өсвөр насны буюу 6+, 12+ насны ангилалтай нэвтрүүлэг жилд 130 цагаас багагүй хугацаагаар нэвтрүүлнэ гэж заасан. Үүний дагуу 2025 онд өргөн нэвтрүүлгийн 18 телевиз нь балчир нас буюу 3+ насны ангиллын 1944 цаг, бага нас (6+) болон өсвөр нас (12+)-ны ангилалтай 2503 цагаар нэвтрүүлсэн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад 3+ насны ангиллын нэвтрүүлэг 567 цагаар, 12+ насны ангиллын нэвтрүүлэг 338 цагаар тус тус өсжээ. Тухайлбал, Централ телевиз нь 2024 онд хүүхдийн 3+ насны нэвтрүүлэг нэвтрүүлээгүй байсан бол 2025 онд тухайн насны ангилалд шинэ бүтээл бэлтгэн нэвтрүүлж “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10.3 дахь заалтыг биелүүлсэн. Харин NTV, SBN, Боловсрол суваг, Монгол HD, ТВ9 телевизүүд нь өнгөрсөн оныхоосоо цагаа нэмэгдүүлж “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10.3 дахь заалт буюу балчир нас буюу 3+ нэвтрүүлгийг цагийг бүрэн хангаж ажилласан байна.

Бага нас 6+ болон өсвөр нас 12+ насны ангиллын нэвтрүүлгийн хувьд Тэнгэр, NTV, Сүлд, ТВ5 телевизүүд 2025 онд тухайн насны ангилалд шинэ бүтээл бэлтгэн нэвтрүүлж “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10.2 дахь заалтыг хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Харин Ийгл нь юс телевиз хүүхдийн нэвтрүүлэг огт нэвтрүүлээгүй байгаа нь “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10.2, 3.10.3 дахь заалтуудыг тус тус хангахгүй байгаа тул цаашид хүүхдэд зориулсан нэвтрүүлэг бүтээх, нэвтрүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай гэж үзлээ.

Түүнчлэн хүүхдэд зориулсан нэвтрүүлгийг 2025 онд 8 телевизээр 422:22:59 цагийн дохионы хэлний хэлмэрчтэй, 9 телевизээр 319:25:23 цагийн хадмал тайлбартай бэлтгэн нэвтрүүлсэн байна. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлэг 310 цагаар, хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлэг 119 цагаар өссөн үзүүлэлтэй байна. Мөн “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10.5-д “бага нас 6+ болон өсвөр нас 12+ насны ангилалтай нэвтрүүлгийн нийт цагийн 20 хувиас багагүй дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай байна” гэж заасныг С1 телевиз нь 24%, ТВ5 телевиз нь 32%-тай тус тус ханган ажиллажээ.



Хүүхдийн нэвтрүүлэг нэвтрүүлсэн нийт цаг /3+ нас, 6+ болон 12+ нас /					
Нийт тоо	ТВ	Балчир нас 3+ 2024 он /цаг/	Балчир нас 3+ 2025 он /цаг/	Бага, өсвөр нас 6+, 12+ 2024 он /цаг/	Бага, өсвөр нас 6+, 12+ 2025 он /цаг/
18 телевиз		1377:06.14	1944:36:06	2165:07:32	2503:06:41

2. ОРОН НУТГИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТЕЛЕВИЗ

Тус хороо нь орон нутгийн телевизүүдийн хөтөлбөрт түүврээр хяналт мониторинг хийдэг бөгөөд 2025 онд улирал бүр 10 телевиз түүврээр сонгон хөтөлбөрийн хяналт хийж ажилласан. Иймд орон нутгийн телевизүүдийн үндэсний түүх, соёл, уламжлал, танин мэдэхүйн болон хүүхдийн нэвтрүүлгийн тухайн жилийн нийт цагийг гаргаж, хөтөлбөрт тавигдах шаардлага бүрэн хангаж ажилласныг дүгнэх боломжгүй ба тухайн улирлын явцын дүнгээр тооцон биелэлтийг гаргасан болно.

“Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.12 дахь заалтын хэрэгжилт 2025 оны жилийн эцсээр дараах байдалтай байна.

2.1 “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.12.1-д заасны дагуу орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа өргөн нэвтрүүлгийн телевиз нь жилд 180 цагаас багагүй хугацааны үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлэх үүрэгтэй байдаг. 2024 онд орон нутгийн өргөн нэвтрүүлгийн 38 телевизээр 3850 цагийн нэвтрүүлэг нэвтрүүлсэн бол 2025 оны жилийн эцсийн байдлаар өргөн нэвтрүүлгийн 33 телевизээр 2419 цагийн нэвтрүүлжээ. Орон нутгийн телевизүүдээр нэвтрүүлсэн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн цаг өнгөрсөн оноос буурсан нь мониторингд хамрагдсан телевизийн тооноос хамаарч байна.



Үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн цаг			
Мониторингд хамрагдсан телевизийн тоо	2024 он /цаг/	Мониторингд хамрагдсан телевизийн тоо	2025 он /цаг/
38	3850:48:02	33 телевиз	2419:55:04

2.2 Танин мэдэхүйн нэвтрүүлэг


“Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.12.3-т заасны дагуу орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевиз нь жилд 90 цагаас багагүй хугацааны танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлэх үүрэгтэй. Үүний дагуу 2024 онд 38 телевизээр 1909 цагийн нэвтрүүлэг нэвтрүүлсэн бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 33 телевизээр 1972 цагийн нэвтрүүлэг нэвтрүүлжээ. Энэ нь өмнөх оны нэвтрүүлгийн цагтай харьцуулахад 63 цагаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Танин мэдэхүйн нэвтрүүлгийн цаг			
Орон нутгийн телевизийн тоо	2024 он /цаг/	Орон нутгийн телевизийн тоо	2025 он /цаг/
38	1909:57:09	33	1972:42:35

2.3. Хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн цаг

Орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевиз нь 3+, 6+, 12+ насны ангиллын хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон, хөгжил, хүмүүжил, төлөвшилд нь чиглэсэн танин мэдэхүйн боловсрол олгох нэвтрүүлгийг жилд нийт 150 цагаас багагүй хугацаанд бэлтгэн нэвтрүүлэх үүрэгтэй. Орон нутгийн телевизүүдийн хувьд 2024 онд 38 телевизээр хүүхдийн нэвтрүүлгийг 1304 цагаар нэвтрүүлсэн бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 33 телевизээр 1492 цагаар нэвтрүүлсэн байна.



Хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн цаг			
------------------------------------	--	--	--

Орон нутгийн телевизийн тоо	2024 он /цаг/	Орон нутгийн телевизийн тоо	2025 он /цаг/
38	1304:40:08	33	1492:21:15

3. РАДИОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ

3.1. Тус хорооны 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 87 дугаар тогтоолоор батлагдсан “Радиоогийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10-т заасны дагуу радио нь жилд 360 цагаас багагүй үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн хүргэх үүрэгтэй. ХХЗХ-ноос Улаанбаатар хотын арилжааны 30 радиогоос сард 4 радио түүврээр сонгон, хөтөлбөрт хяналт, мониторинг хийж, явцын тайланд үндэслэн дээрх үүргийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ дүгнэлт гарган ажиллаж байна. 2024 онд сард 10 радиоогийн хөтөлбөрт түүврээр хяналт хийхэд үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлгийг нийт 8787 цаг нэвтрүүлсэн бол 2025 онд сард 4 радиоогийн хөтөлбөрт түүврээр хяналт мониторинг хийхэд жилийн эцэст 5212 цаг нэвтрүүлжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулбал 32 хувиар өссөн үзүүлэлт болж байна.



Үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлгийн цаг			
Улаанбаатар хотын радиоогийн тоо	2024 он /цаг/	Улаанбаатар хотын радиоогийн тоо	2025 он /цаг/
Сард 10 радио	8787:12:20	Сард 4 радио	5212:13:37